



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 08 -ны өдөр

Дугаар А/48

Эрдэнэт

"Хөрөнгө гаргах тухай"

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг сунгах тухай" А/24 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны "Тусгаарлах эмнэлгүүд ажиллуулах тухай" А/166 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдвар/Ковид-19/-ын нөхцөл байдал хүндрэх үед хөнгөн хэлбэрийг тусгаарлах эмнэлэгт ажиллах үйлчлэгчийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчлэгч нарт мэдлэг олгох сургалтын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Сургалтын үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Хүний нөөцийн төлөвлөлт хангалт сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн /М.Ариун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Шаардлагатай 82.400 /Наян хоёр мянга дөрвөн зуун төгрөг/-ийг төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal

БАТЛАВ.
ЭМГ-ЫН ДАРГЫН АЛБАН ГҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Сүхээ* Д.СҮХЭЭ

ТУСГААРЛАХ ЭМНЭЛЭГТ АЖИЛЛАХ ҮЙЛЧЛЭГЧ НАРТ АЖЛЫН БАЙРАНД
ШААРДАГДАХ МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Зорилго: Тусгаарлах эмнэлэгт ажиллах үйлчлэгчид ажлын байранд гүйцэтгэх үүрэг, хувцас, багаж хэрэгсэлтэй ажиллах чадвар эзэмшүүлж, хүний нөөцийн бэлэн байдлыг хангуулахад чиглэгдэнэ.

Сургалтын чиглэл:

-Хамгаалах хувцас зөв өмсөх, тайлах дараалал-БОЭТ-н Ариутгалын тасгийн сувилагч Э.Ууганцэцэг

-Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис хэрэглэх заавар, багаж хэрэгслийг ажиллуулах дадлага олгох –БОЭТ-н Ариутгалын тасгийн сувилагч Л.Алтантуул

Сургалтын үр дүн: Тусгаарлах эмнэлэгт ажиллах үйлчлэгчид ажлын байранд цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлнэ.

Сургалтад оролцогч: Сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулиудын үйлчлэгч нар оролцоно. Нэг удаагийн танхимын сургалтад 15-аас дээшгүй хүн халдвар хамгааллыг сахиж, хүн хоорондын зай баримтална.

Зохион байгуулагч: Эрүүл мэндийн газар

Хугацаа:

2021.05.03-ны өдөр ЭМГ-н НЭМТ-н сургалтын зааланд 10.00-13.00 цаг,
13.00-16.00 цаг, 16.00-19.00 цаг цагийн хооронд зохион байгуулагдана.

Шаардагдах төсөв:

д/д	Материалын тооцоо	Хугацаа	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд	Сургалт явагдах газар
1	Кг/ чихэр	1 хоног	2 кг	15000	30000	Нийгмийн эрүүл мэндийн төв
	кофе	1 хоног	1	8400	8400	
2	Печень /джек/	1 хоног	2 кг	9500	19000	
3	чацаргана	1 хоног	5	5000	25000	
Нийт дүн-82400						

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ЭМГ-ын хүний нөөцийн төлөвлөлт

хангалт сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн *М.Ариун-Эрдэнэ* М.Ариун-Эрдэнэ